



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 4/166

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгт өөрийн хариуцсан сум орон нутгийн тусгай мэргэжлийн анги, аж ахуй нэгж, байгууллагыг ой хээрийн түймэртэй тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллаагүй, аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгт өөрийн биеэр оролцож чадахгүй болсныг урьдчилан мэдэгдээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүй ажил таслан зөрчил гаргасан Жаргалтхаан сумын Засаг дарга Б.Цогт-Орших, Өмнөдэлгэр сумын Засаг дарга Б.Эрдэнэбаатар, Дархан сумын Засаг дарга Ж.Энхтөр, Батноров сумын Засаг дарга Г.Тайванжаргал нарыг сонсох ажиллагааг хийх итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх хяналтын тасгийн дарга дэд хурандаа Н.Чанцал, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч дэд хурандаа Т.Чулуунбаатар, Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч ахмад Р.Батсайхан нарыг томилсугай.

2. Сонсох ажиллагааг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу хийж гарсан саналыг 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр танилцуулахыг аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх хяналтын тасгийн дарга дэд хурандаа Н.Чанцал, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч дэд хурандаа Т.Чулуунбаатар, Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч ахмад Р.Батсайхан нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 768